

ИНТЕРНЕТ СЭТГҮҮЛ ЗҮЙН ҮНДСЭН ОЙЛГОЛТ

Б.Болд-Эрдэнэ*

* МУИС, НШУС, Сэтгүүл зүйн тэнхмийн багш, доктор (Ph.D.), дэд профессор

Түлхүүр үг: Интернет сэтгүүл зүй, сансрын технологи, Интернетийн орчин, хөрвөгч бичвэр, төсөөллийн ертөнц, тоон хувьсгал, эргэх холбоо, хөдөлгөөнт чанар.

Интернет сэтгүүл зүйн тухай өгүүлэхэд хорьдугаар зууны нэгэн гайхамшигт үйл явдал, түүний мөн чанарын талаар ярих ёстой. Интернет нь тоон технологи, компьютер төвт мэдээлэл, харилцааны орчин гэхээсээ илүүтэй орчин үеийн хүн, нийгмийн эрэлт хэрэгцээ, дэг журам, сэтгэлгээ үнэлэмжид гарсан их өөрчлөлтийн үргэлжлэл, “үр жимс” гэдгийг онцлох ёстой.

Энэхүү орчин үеийн тоолол 1919 оны 5-р сарын 29-ний өдөр баруун Африк, Бразилд хийсэн нар хиртэлтийн зургаар баттай нотлогдсон нэгэн шинэ, ер бусын нээлтийн тухай дуулиант мэдээгээр эхэлж, эдүгээ хүртэл үргэлжилж байна. Энэ бол аль 1905 онд Германы жүүд, 26 настай А.Эйнштейн хэмээх залуугийн дэвшүүлсэн “харьцангуй онол” гэж алдаршсан ертөнцийн зүй тогтлын шинэ үзэл баримтлал орчин үеийн сэтгэлгээний “үнэн, луужин” болсон түүхийн эхний зогсоол байсан юм. Ийнхүү Евклидийн

шугаман өнцөгт геометр, Галилейн мөнхийн цаг хугацааны сургаалд үндэслэгдэн 200 гаруй жил хүн төрөлхтний оюун ухаанд ноёрхож байсан И.Ньютоны ертөнцийн дэг журам үндсээрээ “засвар”-т орж, “мөнхийн, төгс, туйлын” гэсэн бурхны номлолд цэг тавьжээ. Тиймээс А.Эйнштейн дэлхийн “од” болж, их дээд сургуулиудад зочилж, хүмүүс бүчин, түүний онолыг тайлбарласан олон ном зохиолууд ч гарчээ.

Гэхдээ хамгийн гол нь “бүхнийг харьцангуй, мөнхийн бус” гэсэн гажиг хачин, бурхны итгэл үнэмшлийн эсрэг зогссон онолыг “үнэн зөв” хэмээн бүх нийтээр хүлээн зөвшөөрөхөд Дахин сэргэлт, газар зүйн их нээлт, аж үйлдвэржилтийн хувьсгал, эрх чөлөө, зах зээлийн үзэл санаа зэрэг хүний оюун ухааны орон зай, хүрээний тэлэлт, түүний үр дагавар болох өөр, шинийг хүсэн тэмүүлэгч “сэтгэлгээний хүлээлт” байлаа. Хүмүүс илүү өөрчлөлт, санаандгүй үйл явдал, хурд, ер бусыг хүсч, хүлээх боллоо. Урлаг, утга зохиол, шашин шүтлэг, гүн ухаан бүгд шинэ эрин, цаг үеийнхээ тусгал, “сүүдэр” нь байж сая үнэ цэнэтэй, чухал хэмээгдэх болов. Олон нийтийн бүхэн арилжаа-

лагдаж, тэр чинээгээрээ эрс өөр, шинэ, санаандгүй бүхнийг эрэлхийлж эхлэв. Нөгөө талаар хувцас эдлэл, ахуй байдал тэр бүү хэл хүн өөрөө хүртэл цаг үеийн, өөрчлөлтийн дүр бэлгэдлийн хэрэгсэл болжээ. Мэдээж ийм өргөн, гүн гүнзгий нөлөө, өөрчлөлтийн эхлэлийг “харьцангуй онол” авчирна гэж А.Эйнштейн өөрөө ч төсөөлөөгүй төдийгүй бүр эсэргүүцэж байсан юм.

Гэвч радио, телевиз, сансрын технологи гээд орчин үеийн хэрэглээ, олон нийтийн соёл, сэтгэлгээ, дэг журмыг цаг үе, өөрчлөлтийнх болгон тунхаглах хэрэгслийн түүчээ тасраагүй юм. Эдийн засаг, улс төрөөс гэр бүлийн харилцаанд хүртэл “сондгойрох” үзэгдэл эрчтэй болоод тэргүүлэгч бахдан тэмүүлэх төв нь болсон юм. Уламжлалт нийгэм, хүний үеийн “туйлын, төгс, мөнх”-ийн үнэлэмж, орь хүсэл, сэтгэлгээ үгүй болж бүхнийг мэддэг, хэрэглэдэг, өөрийн болгодог эрин үе хүчээ авсаар байв.

Интернет ч дээрх бүхнийг түүчээлэн, хүн нийгмийн түүхэнд өөрийн орон зай, байр сууриа эзэлсэн юм. Тиймээс Интернет сэтгүүл зүйг соёл иргэншил, харилцаа, нийгмийн шинэ үзэгдэл хэмээн ойлгох ёстой. Гэхдээ мэдээж мэдээлэл, утга агуулгыг үг хэл, дуучимээ, дүр зураг, хөдөлгөөнт дүрс, өнгө

гээд бүх хэлбэрт оруулан дамжуулж, түгээж, хадгалж болох өргөн боломж, стандартчлагдсан орчинд Интернет сэтгүүл зүйг тодорхойлох нь ойлгомжтой. Ийнхүү компьютер мэдээллийг цаг хугацаа орон зайн хязгааралт, эрхшээлээс ангид, бие даасан, чөлөөтэй “хөвөгч” болгосон төдийгүй түүнийг зөвхөн хүртэх, хэрэглэх (унших, сонсох, үзэх)

«

Хамгийн гол нь “бүхнийг харьцангуй, мөнхийн бус” гэсэн гажих хачин, бурхны итгэл үнэмшлийн эсрэг онолыг “үнэн зов” хэмээн бүх нийтээр хүлээн зовишоороход Дахин сэргэлт, газар зүйн их нээлт, аж үйлдвэржилтийн хувьсгал, эрх чөлөө, зах зээлийн үзэл санаа зэрэг хүний оюун ухааны орон зай, хүрээний тэлэлт, түүний үр дагавар болох өөр, шинийг хүсэн тэмүүлэгч “сэтгэлгээний хүлээлт” байлаа.

»

гид бие даасан өөр нэг ертөнц Интернетийн орчинд байна гэсэн үг. Энэ ертөнц өөрийн гэсэн дэг журам, соёл, харилцааг бий болгож бодит нөхцөл амьдралд ч нөлөөлөх, харилцан нөхцөлдөх болжээ. Тиймээс ч мэдээллийн нийгэм, гурав дахь эрин гэсэн ойлголт гарсан хэрэг.

Мэдээллийн нийгмийн тухай олон зш үзэл, онол, тайлбар бүр үгүйсгэл ч бий. Гэхдээ ерөнхий шинж чанар, төлөв байдлыг нь тоочсон жагсаалт байдаг.

төдийгүй зохиох, бүтээх, харилцах түгээмэл хэл тэмдэгтийн орчин болгож чадсан юм. Мэдээлэл, харилцааны бодит нөхцөл байдлаас шууд хамаардаг мөн чанарт ч эргэлт авчирч, “тоон, тэмдэгтийн” өөрийн гэсэн нийгэмшил, дэг журам, ахуй ертөнцийг бий болголоо. Өөрөөр хэлбэл мэдээлэл, тэмдэгтийн бодит байдал, нийгмээс ан-

Энэхүү жагсаалт ч мэдээллийн нийгмийн мөн чанарыг товч бөгөөд тодорхой өгүүлдэг тул тоочсу. Үүнд:

- Бүтээгдэхүүн үйлдвэрлэлтээс илүү үйлчилгээ рүү чиглэсэн эдийн засаг;

- Үйлдвэрлэлийн салбар дахь мэдлэгт тулгуурласан технологийн хүчин зүйлийн өсөлт, нөлөө;

- Материаллаг баялгийн нөлөө, байр суурийн үнэлэмжийн тогтолцоо дахь бууралт (үнэгүйдэл);

- Нийгэм-улс төрийн байгуулалт, бүтэц болон технологийн хөгжлийг дагасан мэдлэг, мэдээллийн дээдлэл;

- Нийгмийн амьдрал, ялгарал, бүтэцэд нөлөөлөх агуулга, бэлгэдлийн байр суурийн тэргүүлэл;

- Мэдлэгийг бүтээгч үнэлэмж, ухамсар бүхий бие хүн, шинэ ёс суртахуун, боловсрол гэгээрлийн давуу байдлыг хөхиүлэн дэмжсэн ноёрхогч хандлага, эрхэмнэлд суурилсан соёл сэтгэлгээний өөрчлөлт;

- Их сургуулийн (боловсрол, шинжлэх ухаан) нийгмийг хөдөлгөгч нөлөө, хүчин зүйлийн үндэс, тулгуур болох үзэгдэл эдгээр болно.

Энгийнээр хэлбэл мэдээллийн нийгэм нь мэдлэг, үзэл санааг үйлдвэрлэгч бүтээгч ертөнц юм. Мэдээж энэхүү онцлог хандлага нь ч сэтгүүл зүйн хөгжил, мөн чанарт нөлөөлж байна. Үүний шалтгаан нь энгийн бөгөөд бүгдэд илт болох хүн нийгмийн харилцаа, амьдралын нэгээхэн хэсэг, үргэлжлэл болж сэтгүүл зүй оршин байдагт юм. Үнэхээр ч сэтгүүл зүй нь олон нийтийн санаа бодлын “удирдаач” хэмээх утгаараа нийгмийн орчин, төлөв байдал, янз бүрийн үнэлэмж, хандлагыг төлөвшүүлдэг. Харин тэр бүхэн нь эц-

сийн эцэст мэдээллийн түгээлт, дамжуулал, харьцаа зэрэг хүний амьдрал, төрөлх эрэлт хэрэгцээгээр тэжээгдэн байж, нийгмийн орчин, харилцааны тогтолцоог бий болгон төлөвшүүлдэг учиртай. Товчхондоо сэтгүүл зүй нь хүний харилцаагаар эхэлж, бас үргэлжилдэг мэдээллийн хүрд юм. Тэгээд ч нийгэм бүхэлдээ болоод түүний нийтлэг бүр үг яриа, тэмдэгтийн орчин, мэдээллийн хэрэгсэл, харилцааны технологи гээд янз бүрийн хэлбэр, хэрэглүүрийн нөлөө, хүчин зүйлс дор төлөвшиж бидний ярьдгаар төсөөллийн ертөнцийг (виртуал — орон зай, цаг хугацаа, мөн чанар зэрэг ойлголттой адил гүн ухааны өвөрмөц ухагдахуун) бүтээдэг.

Энэ ч үүднээс виртуал ертөнц нь гүн ухаан, соёл судлал, нийгэм, сэтгэл судлалын хүрээнд зайлшгүй хөндөгддөг орчин үеийн асуудал болоод байна. Виртуал ертөнц бодитоор оршиж, бидний цаг үе, ахуй байдлаа үнэлэх ойлгох гол эх сурвалж болон шинэ шинэ боломж, суваг орон зайг бий болгосоор байгаад гайхах зүйлгүй. Хүний харилцаа түүний эрэлт хэрэгцээ хязгааргүйн адил виртуал ертөнц ч өргөн уудам юм. Нөгөө талаар виртуал ертөнцийн уудам зайд сэтгүүл зүйн хөгжил, өөрчлөлт ч тасралтгүй үргэлжилж, хүний нийгмийн дангааршил хийгээд даяарчлалын бүхий л хүрээд улам бүр нэвчсээр байна. Тиймээс ч ОНМХ нь мэдээллийн орон зайн тулгуур үндсэн хангагч, бүрдүүлэгч бас төлөвшүүлэгч тогтолцоо болж байдаг юм.

Харин Интернетийн хувьд мэдээллийн төдийгүй харилцааны хэрэгслийн үүргийг нэгэн зэрэг агуулж байгаагаараа

чанарын хувьд цоо шинэ өөрчлөлт нөлөөг сэтгүүл зүйд үзүүлж байна. Энэ ч үүднээс сэтгүүл зүйн ирээдүй, хөгжлийн чиг хандлагыг мэдээлэл түгээх, дамжуулахаасаа илүү харилцааны хэрэгслийн тогтолцооны хүрээнд томьёолох ёстой. Өөрөөр хэлбэл мэдээллийн орон зайн виртуал ертөнцтэй холбогдогч олон нийт, хэрэглэгчдэд нээлттэй технологийн цогцод суурилсан даяар харилцааны суваг, сүлжээ болон уламжлалт мэдээллийн хэрэгслийг орчин үеийн сэтгүүл зүйн онцлог, өнгө төрх гэж болно.

Нөгөө талаар Интернет болон сэтгүүл зүйн нэгдэгшил нь эдүгээ цагийн цоо шинэ соёл сэтгэлгээний үзэгдэл болж байгаа утгаараа иргэншил, нийгмийн харилцааны цөм хүчин зүйлийн төвшинд хүрчээ. Тэгээд ч Интернетийн сүлжээ, Интернет сэтгүүл зүйн даяарчлагдсан дэлхий ертөнцийн соёл иргэншил, үнэлэмжтэй холбон ойлгох ёстой. Энд мэдээллийн технологийн хөгжил, хэт бэлэгдлийн эдийн засаг бүхий мэдээллийн нийгмийн төлөвшил болон уламжлалт сэтгүүл зүйн нөлөө, уялдаа холбоо гэсэн 3 хүчин зүйлийн огтлолцол дээр Интернет сэтгүүл зүйг тодорхойлох болоод байна гэсэн үг.

Ийм шалтгаан, үндэслэлээр Интернет сэтгүүл зүй нь олон нийтийн харилцаа, мэдээллийн хэрэгслийн судлагдахуунаасаа илүү мэдээлэл зүй, кибернетикийн асуудал болоод байна. Ер нь орчин үеийн сэтгүүл зүйн хөгжил, цаашилбал мөн чанар нь мэдээллийн технологийн засаглал дор оршин бас төлөвшиж байна.

Тэгэхлээр энэхүү сэтгүүл зүй, харилцаа, технологийн нэгдмэл цогц үзэгдлийг тайлбарлахад олон нийтийн мэдээллийн

хэрэгслийн судалгаа, онол номлолынхоос өөр нэр томьёо хэрэгтэй юм. Энд "хамт нийтлэгшил" (сообщение), хийбер бичиглэл (гипертекст) зэрэг үндсэн ойлголтоор дамжуулан Интернет сэтгүүл зүйг эргэх холбоот мөн чанар бүхний орчин үеийн харилцаа холбооны даяарчлагдсан орон зайн олон нийтийн харилцаа, мэдээллийн орчин хэмээн тодорхойлж буй хэрэг.

Үнэхээр ч Интернет сэтгүүл зүйн мэдээллийг зөвхөн агуулга тэмдэгтийн талаас авч үзэх нь учир дутагдалтай бөгөөд эргэх холбоо, шууд харилцаа, хайлтын хэрэгцээ, эс олон нийтшилт гээд хэрэглээ, түгээлт дамжуулал, үйл ажиллагааны зарчмын хувьд уламжлалт мэдээллийн хэрэгслийнхээс эрс өөр байгаа юм. Хөрвөгч бичвэр л гэхэд шрифт, дүр, өнгө, дуу чимээ, хөдөлгөөнт дүрс гээд өргөн нэгдмэл тэмдэгтийн орчинд, бодит юм, үзэгдлийн байдлыг тусгагч, дамжуулагчаасаа илүү өөрийн ахуй ертөнцийг бий болгон бүтээгч тогтолцоо болоод байна. Тиймээс Интернет сэтгүүл зүйн тухай өгүүлэхэд хөрвөгч бичвэрийн тухай ойлголт онцгой чухал төдийгүй үндсэн гол ойлголт болно.

Өөрөөр хэлбэл сонин хэвлэл, телевиз, радио мэдээллийн хувьд агуулга хэлбэр, зохиогчийн ур чадвар, цаг үе, хэрэглэгчийн эрэлт, санаа бодол зэрэг хүчин зүйлс шүүмж, дүгнэлт, онол номлолынх нь тулгуур байдаг бол Интернет сэтгүүл зүйд хөрвөгч бичвэртэй холбоотой технологи, программ хангамж, нэгдмэл стандарт хэл, хүртээмжийн хүрээ, хүрд гэсэн асуудлууд илүү тайлбарлагдах болно.

Нөгөө талаар Интернет сэтгүүл зүйг шинэ технологийн боломж, хэрэгслийг ашигласан сэтгүүл зүй хэмээн хялбарчлан ойлгож болохгүй. Ийм үзэл хандлагаар ч онлайн сэтгүүл зүй, веб-сэтгүүл зүй, кибер сэтгүүл зүй, цахим сэтгүүл зүй гэх зэргээр тодорхойлж үзсэн нь бий. Хэдийгээр дээрх нэр, хэллэг адил утгатай, асуудлын аль нэг тал онцлогт үндэслэсэн боловч цогц, бүрэн дүүрэн томъёолол болж чадахгүй. Учир нь өмнө өгүүлсэнчлэн Интернет сэтгүүл зүй нь соёл иргэншил, нийгэм эдийн засаг, улс төр, хувь хүний амьдралын хэв маяг, үнэлэмж зэрэг, өргөн хүрээг хамарсан нөлөө бүхий үзэгдэл юм.

Түүнчлэн мэдээллийн хэрэгслийн Интернет хувилбарыг сэтгүүл зүйгээс сонин хэвлэл, телевиз радиог Интернетээс ангид тусад нь ойлгох ёстой. Тэгэхлээр Интернет хувилбар нь даяар мэдээллийн сүлжээний хязгаарлагдмал тодорхой боломжийг ашигласан хэлбэр харин уламжлалт хэрэгсэл нь эргэх холбоо, шууд хариу, харьцаа, эс олон нийтшилт, хайлт зэрэг мөн чанар үгүй нэг талын, шууд бус, бүх нийтэд зориулсан харилцаа юм. Гэхдээ бас Интернет сэтгүүл зүй нь дээрх хоёр эсрэгцлийн аль алинд ойртохуйц мэдээлэл харилцааны үзэгдэл гэдгийг ч үгүйсгэж болохгүй.

Тэгвэл Интернет сэтгүүл зүй гэж юу вэ? Асуултын хариуг ойлгомжтой болгохын тулд сэтгүүл зүйн тодорхойлолтоос эхлэх ёстой. Профессор М.Зулькафиль сэтгүүл зүйн онцлогийг "...олон түмэнд (зөвхөн тооны хувьд төдийгүй, шинж чанарын хувьд) хандсан, тэдний нийгмийн амьдралд болон ухамсарт нөлөөлөхүйц чухал гэж үзсэн баримт, асуудал,

үйл явдал, үзэгдлүүдийг маш өргөн, янз бүрийн хүрээнд тусгасан, түүгээр дамжуулан тогтмол хэвлэл, радио телевизийн нэвтрүүлэгт өдөр тутмын нийгмийн амьдралын дүр зураг, орчин цагийн дүр төрхийг бүтээдэг"¹ хэмээн тодорхойлсон нь бий. Мөн Оросын нэр хүндтэй профессор Е.П.Прохоров "... сэтгүүл зүй нь мэдээлэл үгүйгээр нийгмийн өмнө хүлээсэн үүргээ гүйцэтгэх ямар ч арга боломжгүй юм. Мэдээлэл нь сэтгүүл зүй ба олон нийтийн хооронд амьд, хөдөлгөгч хүчин зүйл нь байж сая нийгмийн өвөрмөц бие даасан тогтолцоо байх олон янзын өргөн хүрээ бүхий зорилгодоо хүрнэ.

Энэхүү үндэслэл тайлбар нь ч сонин хэвлэл, радио телевиз зэргийг багтаасан цогц тогтолцоо болох сэтгүүл зүйг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл хэмээн тодорхойлоход хүргэдэг"² гэжээ. Эдгээр тодорхойлолтоос үзэхэд сэтгүүл зүй нь цаг үеийн, шуурхай, мэдээллийн орон зайг төлөвшүүлэгч хэрэгслүүдийн бүхий л хэлбэрийг ашиглан үг хэл, дүр дүрслэл, утгат тэмдгийг боловсруулан түгээн дамжуулах цогц үйлдвэрлэл хэмээж болно. Мэдээж үүний дээр нийгэм, олон нийтийн эрэлт сонирхлыг хангах зорилго бүхий, тэмдэгт агуулгыг бүтээх мэдээллийн технологид түшиглэсэн зохиогч, мэдээлэгчийн ур чадвар, сэтгэлгээний бүхий л үйл ажлыг нэмэх ёстой. Ийм чанар шаардлага ч Интернет сэтгүүл зүйд бий. Ер нь сэтгүүл зүйг томъёолоход сэтгүүлчийн хүчин зүйлийг онцлох нь зайлшгүй бөгөөд сонин хэвлэл эрхлэн гаргагчдын эрин үе болох ХҮИ-ХІХ зууны үед ч хэл найруулга, зохиомж, төрөл

зүйлийг, дараа нь загвар дэглэлт, гарч-гийн хэмжээ илэрхийллийг чухалчлан байсан нь санаандгүй хэрэг биш. Тэгэхлээр ямар сэтгүүлч байна тийм сэтгүүл зүй оршино гэсэн мөрдлөг бүх цаг үед хүчинтэй гэсэн үг.

Анхны сонин хэвлэл гарч байх үеэс мэдээ мэдээллийг эмхэтгэн нэгтгэгч ажилтныг мэдээч, харин дараа нь цаг үеийн үйл явдлын тайлан, дэлгэрэнгүй тайлбар бичигчийг сурвалжлагч, сонины ажилтан зэргээр нэрлэж хөдөлмөрийн хуваарилалт хийж байжээ. Нэн ялангуяа Америкийн сэтгүүл зүйд сурвалжлагч, нийтлэлч, мэдээч нарын үүрэг, анги ялгаа илт тодорхой болж төлөвшсөн гэдэг.

ХҮIII зууны үеэс Европын сонин хэвлэлийн үечлэлийн давамж багасан, шуурхай байдлаа алдаж, мэдээллийн агуулгад нь нийтлэл, эсээ, тойм, тайлбар бүр шог хошин бичлэг давамгайлах болсноор “сэтгүүл” хэмээх ойлголт ялгарч тодрох шалтгаан үүдэв. Тиймээс ч сэтгүүл нь бий болсон цагаасаа нийгэм соёлын сэтгэлгээний төв, улс төр, урлаг утга зохиолын индэр болон төлөвшсөн хэрэг. Монголчуудын анхны тогтмол хэвлэл “Шинэ толь хэмээх бичиг” ч соён гэгээрүүлэгч, нийгмийн тэргүүлэгч хэсгийн үзэл бодлыг илэрхийлэгч, нийтлэл, өгүүллийн дэвтэр бичиг байсан нь сэтгүүл зүй хэмээх нэр томъёо олон нийтийн мэдээллийн хэрэгслийг тодор-

хойлох бодит шалтгааны эх үндэс байжээ. Ийнхүү сонин болон сэтгүүлийн ялгаа, онцлог үечлэл, бичлэгийн төрөл зүйлийн давамгайлал, агуулга, загвар дэглэлтийн хүрээнд тодорч, хөгжин төлөвшсөөр иржээ.

Харин Интернет сэтгүүл зүй бий болсноор сэтгүүл, сонины үндсэн ялгаат байдалд өөрчлөлт гарч, нэгэн орон зайд нэгтгэгдэх болов. Интернет үйл явдал баримт, мэдээллийг эгшин зуур, шууд, эргэх холбоо бүхий технологиор олон нийтэд хүргэх боломжийг бүрдүүлэхийн хамт мэдээ болон нийтлэл зүйн бүтээлийг нэгэн зиндаа төвшинд, өөр хоорондоо уялдаа холбоотойгоор дэлгэх “орон зай”-г нээсэн юм.

Ийнхүү мэдээ нь тайлбар, дүгнэлт, үзэл бодлын төв, тэдгээрийг өрөөгч нэгтгэгч, холбогч бас нотлогч агуулга сэдэв боллоо. Мөн бичлэ-гийн төрөл зүйлийн ялгаа бүдгэрч, сурвалжлага хөрөг, мэдээ өгүүллийн хооронд “тэг хуруу зайтай” болсон нь ч Интернет сэтгүүл зүйн онцлог аж.

Хөгжил өөрчлөлтийн “ороомог” хувь тавилангаар сэтгүүл зүйн өмнөх үеийн дүр зураг Интернет орчинд бий болжээ. Хэвлэмэл сониноос өмнө мэдээллийг түгээгч, дамжуулагч нь зар түгээгч, үлгэрч туульч, наймаачин, холын гийчин, өвгөд хөгшид байсан бөгөөд өнөөгийн жишгээр нийгмийн харилцааны гол

мэргэжилтнүүд, олон нийтийн ухамсар, санаа бодлыг төлөвшүүлэгчийн үүрэг, ачааг тээж явжээ. Энэ тухай ч профессор Л.Норовсүрэн "...зочин гийчин, алсын аян жингээс буусан нутаг нэгтэн хэнийг ч болов тосон угтаж, гэр хотол, айл саахалтаараа нэгэн гэртээ цуглан хол ойрын сонин дуулж, шөнө дөл болтол ярилцдаг нь нүүдлийн соёл иргэншилт ард түмний аж төрөх өвөрмөц ёс, амьдрал ахуйд ашигтай шинэ сонин мэдээлэл олж авах арга юм"³ гэж тэмдэглэжээ. Тиймээс ч өнөөдрийн блогчид, сайт эзэмшигчид, сэтгэгдэл бичигчид зэрэг Интернетийн хувь мэдээлэгчид бол уламжлалт нийгмийн үеийн холын зочид, сонин хачиныг дуулгагсад, аман мэдээч нартай адил ижил үүрэг, нөлөө бүхий мэдээллийн эх сурвалж болж байна. Цаашилбал Интернет сэтгүүл зүйн орон зайд аж төрлийн сургаал, зөвлөгөө, үг зохиол, заргын бичиг, захидал, хошин шог яриа, үлгэр домог, хов жив гээд сэтгүүл зүйгээс өмнө байсан аман болон бичгийн бүхий л хэлбэр оршин байна.

Ингээд мэдээллийн технологийн хөгжлийн нөлөөгөөр "тоон хувьсгал" гарч бүгдийг мэдэх, бүхэнтэй харилцах боломж нөхцөл нээгдсэнээр орон зай, цаг хугацааны эрхшээлээс ангижирсан хэрэг. Бичиг үсэг, хэвлэх машин мэдээллийн харилцаа, орон зайг баримт, төсөөлөл, хүнчлэл, адилтгалаар тэжээн тэтгэж мэдээ, сонины агуулга хэзээ ч хэрэг болохгүй асуудлаар дүүрэн ч түүнийг захиалж унших нь орчин үеийн соёл иргэншлийн өдөр тутмын дадал хэвшил болсон юм. Мэдээ мэдээлэл нь хэрэглэгчийн хувьд шууд, хэрэглээний

харьцаа үгүй албаны гадны зүйл байж, түүний үзэл бодол, эрэлт, сэтгэхүйгээр үнэлэгдэн харилцаа, утга тэмдэгт, агуулга гээд бүгд тус тусдаа бие даан оршиж байв. Харин энэ бүхнийг Интернет өөрчлөн байгуулсан юм. Мэдээ олширч бүр хязгааргүй олон болж, үнэгүйдэх нь тэр. Одоо мэдээ ба хэрэглэгч хоорондын харьцаа, эргэх холбоо, бодит хэрэглээ чухал болов. Мэдээ мэдээлэл хөдөлгөөнт дүрс, дүр бэлгэдэл рүү улам бүр хувиран өөрчлөгдөж цоо шинэ үнэлэмж агуулга бүхий харилцааны дэг журам, ахуйг бий болгожээ. Ийнхүү дүрс тойрсон үгэн тэмдэгт бүхий мэдээллийн орон зай бүрэлдэв.

Шигтгээ

Олон нийтийн мэдээллийн үйлдвэрлэлийн онцлог нь үйл явдал, баримт, үзэгдлийг нийгмийн ухамсар, санаа бодолд нэгэнт төлөвшин тогтсон үнэлэмж тэмдэгтийн дэг, холбоонд нийцүүлэн боловсруулах юм. Тиймээс ч мэдээлэл бүр тогтсон тэмдэгтийн хэлбэр, үнэлэмжийн шалгуурт үндэслэсэн дэг байдлаар бүтээгддэг. Бидний авч буй мэдээлэл, үзэж байгаа телевиз, киноны үйл явдал нь бодит жинхэнэ, дүр дүрслэл бус харин түүний тухай тэмдэгт илэрхийллийн дэг, үнэлэмжид тулгуурлан боловсруулсан бүтээгдэхүүн юм. Бидний уншиж ойлгож, дүгнэж буй бүхэн бидэнд уншиж ойлгоход хялбар, нэгэнт тогтсон тэрхүү дэг, хэлбэрээр боловсруулагдсан байдаг. Тэгэхлээр олон нийтийн мэдээллийн хэрэгслийн агуулга мэдээний утга, хэв маяг, үнэлэмж, чанарыг судлах нь сэтгүүл зүйг ойлгох гол түлхүүр, багаж зэвсэг нь байдаг. Тэгээд ч судлаачдын үзэж байгаагаар мэдээллийн тэмдэгт бэлгэдлийн загвар хэлбэр нь харилцааны дамжуулал, түгээлтэд илүү хялбар боломж, давуу талыг бий болгож байгаа юм. Тэмдэгт,

мэдээллийг бүтээх, хувиргах нь шууд утгаараа харилцааны үйл явцаас ангид, бие даасан зүйл боловч шийдвэрлэх чухал нөлөөтэй байдаг.

Сэтгүүл зүйн үйл ажиллагааг ерөнхийд нь “мэдээлэл—харилцаа—хэрэглэгч” гэсэн загвар бүтцээр тодорхойлж ирсэн. Харин үүнийг Интернет сэтгүүл зүйн онцлог, ялгаанд үндэслэн “хамт нийтлэгшлийн ахуй—хамт нийтлэгшил—хүн” гэсэн гурвалаар томъёолж болно.

Энд “хамт нийтлэгшил” хэмээх ойлголтыг хүмүүс ба бодит байдлыг нөхцөлдүүлэх сэтгүүл зүйн үүр-гийн мөн чанарыг тодотгоход хэрэглэж байгаа юм. Мэдээж энэхүү эрхшээгдсэн ахуй нь баримт нотолгоо болгон төлөөлүүлж буй мэдээллийн дүр дүрслэлээр бий болдог. Тэгээд ч мэдээлэл зохиогчийн хувь хүний дүр төсөөлөл бүхий агуулга нь илүү төсөөллийн, бүтээлч мөн чанарыг агуулдаг. Мөн бие хүний оюун санааны эрх чөлөө болгож бодит байдлыг өөрийнхөөрөө сэтгэх, мэдрэх хувь чанарыг мэдээллийн ертөнцөд хүлээн зөвшөөрдөг. Мэдээж хувь хүний үзэл хандлага тодорхой бүлэг хүрээний эрх ашиг сонирхлоор бүх нийтийн, туйлын үнэн болбол муу хэрэг. Ийм тохиолдол бусдыг өөрийнхөөрөө байх эрхийг үгүйсгэж, мэдэл бүхий хэсгийн төсөөлөл бодит үнэн болоход хүргэдэг.

Сэтгүүл зүй нь цаг үеийн бодит ахуй ертөнцийг ч бий болгох нь бий. Хэрвээ өнгөрсөн үед хувь хүний бодит ахуйн талаарх төсөөлөл гадаад хүчин зүйл, мэдээллийн урсгалаас ангид, бие даасан байсан бол өдгөө энэхүү чанар өөрчлөгдөж нийгэм-сэтгэл зүй, мэдээл-

лийн эрхшээлд бүрэн автжээ. Бодит байдал ч ихээхэн хэмжээгээр харилцаа мэдээллийн орон зайд байр суурь, нөлөөгөө алдаж, бэлгэдэл, төсөөлөл, дүр зэрэг нь ахуйг эрхшээх болов. Өөрөөр хэлбэл мэдээллийн дүр дүрслэл, агуулга нь бодит байдлаас ангид ялгаатай байсан ч “үнэн зөв” болон хүмүүсийн сэтгэл, оюун ухааныг эзэгнэж байна гэсэн үг. Тиймээс ч энэхүү шинэ эрхшээл, нөлөөллийн хүч, байр суурийг холбоо харилцааны технологийн хөгжлөөр тэтгэгдсэн Интернет сэтгүүл зүй улам бүр батжуулсан хэрэг. Тэгэхлээр Интернет сэтгүүл зүй болон ийм хэлбэрийн харилцаа нь орчин үеийн нийгмийн амьдрал, тогтолцооны нэгз-хэн хэсэг ч бүхнийг өөрчлөх нөлөө бүхий хүч болоод байна.

Дэлхийг хэрэн нэгтгэн сүлжсэн Web ба шинэ сэтгүүл зүй

Гурван W буюу World Wide Web хэмээх дэлхий дахиныг бүрхсэн мэдээллийн сүлжээ нь сэтгүүл зүйн үйл ажиллагаанд дараах шинэ онцлог, давуу талыг бий болгожээ. Мэргэжилтнүүдийн тодорхойлсноор даян дэлхийн Вэб сүлжээ нь:

- Эргэх холбоо
- Хэрэглэгчийн бие даасан оролцоо
- Мэдээллийн дан төвлөрөл
- Эгшин зуурын холбоо
- Хэрэглээний тоон хэмжигдэхүүн
- Хөдөлгөөний чанар
- Харилцамж
- Хямд хэрэглээ хэмээн тоочиж

болох шинэчлэлтээр баяжуулжээ.

Эргэх холбоо

Сэтгүүл зүйн нэг талын, мэдээлэгчээс хэрэглэгч рүү хандсан урсгалт байдлыг

вэбийн эргэх холбоот, шууд дамжууллын технологи өөрчлөн эргэх холбоо бүхий харилцааны төвшинд хүргэсэн. Үнэхээр ч мэдээллийн технологийн дэвшил хөгжил сэтгүүл зүйн мөн чанарт шинэчлэлт хийж, бичлэгийн арга барил, төрөл хэлбэр, түгээлт дамжуулал бүр бүтэц зохион байгуулалтад ч өөрчлөлт, хөдөлгөөнийг бий болгосон. Мэдээллийн сүлжээ нь сэтгүүл зүйд тодорхойгүй, түгээмэл хэв шинжит уншигч, үзэгч сонсогчидтой харилцдаг байсан уламжлалыг шинэтгэж хэрэглэгчдийнх нь эргэх хариу, хандлагыг мэдэх боломжийг авчирсан юм.

Хэрэглэгчийн бие даасан оролцоо

Вэбийн орчин нь хэн ч эсхүл ямар ч хэсэг бүлэг өөрсдийн мэдээлэл харилцааны эрэлт хэрэгцээгээ хангах бүхий л хэлбэрийн нөхцөл боломжийг бий болгосон.

Мэдээллийн дан төвлөрөл

Хэрэглэгч өөрийн сонирхож буй, хэрэгцээт мэдээллээ нарийн тодорхой ангилан ялгасан эмх цэгцтэй орчинд төөрөгдөл үгүйгээр олж авах боломжийг бүрдүүлсэн. Тэгэхлээр мэдээллийг хайж олох хялбар, ойлгомжтой хэрэглээний орчныг бий болгох нь Интернет сэтгүүл зүйн гол асуудал болж байгаа юм.

Эгшин зуурын холбоо

Интернетийн цогц бүрдэлт сүлжээ нь дамжуулагчаас хэрэглэгч рүү хандсан улам бүр өсөн нэмэгдэж, хямдарч буй мэдээллийн түгээлтийг илүү хурдан, шуурхай болгож байна. Мэдээллийг эгшин зуур дамжуулах чадавхи нь Интернетийг хамгийн шууд, шуурхай хэрэгсэл, суваг болоход хүргэв.

Хэрэглээний тоон хэмжигдэхүүн

Сүлжээ нь нийтлэл мэдээллийн эрэл, хэрэглэгчдийн үнэлэмж, уншилтын тоог тооцох боломжийг бүрдүүлсэн. Энэ нь мэдээллийн зах зээлийг хянах, реклам сурталчилгааны үр ашигтай бодлого хэрэгжүүлэх, нийтлэлчдийн бодит үнэн рейтинг тогтоох зэрэг давуу талыг сэтгүүл зүйд авчирсан хэрэглэгчдийн хандалтын энгийн тоон үзүүлэлт нь (ойролцоо болон яг тодорхой) нийтлэл материалын эрэлт, үнэ цэнийг тодорхойлох чухал шалгуур болно.

Хөдөлгөөнт чанар

Нийтлэл мэдээллийг хүссэн дүр дүрслэл, тэмдэгтээр байршуулан бүтээх, хурдан шуурхай шинэчлэх, нүүрийн баяжилт, байгуулалтад хэрэглэгч хандагсдыг шууд оролцуулах Интернетийн нөхцөл боломж нь идэвхтэй хэрэглээ, агуулга хэлбэрийн тасралтгүй өөрчлөлт, хөдөлгөөний шалтгаан болно.

Хямд хэмнэлт бүхий хэрэглээ

Вэб хуудас нь үнэ төлбөргүй мэдээллийн хэрэгслийн хэлбэр юм. Гэхдээ асуудлын нөгөө талд вэб хэвлэл бүтээхэд өндөр мэдлэг, чадвар бүхий мэргэжилтний оролцоо, үүрэг, чадавхи чухал байдаг. Энд хамгаалалтын найдвартай систем, хайлтын ончтой хэрэглүүр, цонх, өгөгдлийн уян холбоо, мэдээллийн нэгдмэл тогтолцоо зэрэг нарийн бүтэц, технологийг багтаасан хэрэглээ, үйлчилгээний цогц нэгдмэл орчныг мэргэжилтэн бий болгож буй хэрэг. Тиймээс бага (бүр үнэгүйгээр) зардал, өндөр мэдлэг, чадварын хүрээнд вэб хэвлэлийн онцлог оршиж байна гэсэн үг. Тиймээс мэдлэг чадварын адил, боломжит нөхцөлд Интернет сэтгүүл зүй нь бусад мэдээллийн

хэрэгслээс хямд, бага зардлаар бий болж байгаа юм.

Ишлэл

¹ З у л ь к а ф и л ь М. 2004. Сэтгүүл зүйн онолын үндэс. УБ., 14 дэх тал.

² П р о х о р о в Е. П. 2003. Введение в теорию журналистики. М., с. 35.

³ Н о р о в с ү р э н Л. 2000. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. I дэвтэр. УБ., 13 дахь тал.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Б о л д – Э р д э н э Б. 2006. Олон нийтийн харилцаа. УБ.

2. Г а л д а н Т. 2000. Электрон пресс. УБ.

3. З у л ь к а ф и л ь М. 2005. Сэтгүүл зүйн товч тайлбар толь. УБ.

4. З у л ь к а ф и л ь М. 2007. Орчин үеийн сэтгүүл зүй. УБ.

5. Н о р о в с ү р э н Л. 2003. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. III боть. УБ.

6. 2008. Интернет хэрэглэгчийн гарын авлага. УБ.

7. Ц э м б э л Д., Ц э н д ж а в Д., Д а г и й м а а Д., А р и у н Л. 2005. Электрон сэтгүүл зүй. УБ.

8. К о х а н о в а Л. 2007. Интернет-журналистика. Москва.

9. Ч е р н ы х А. 2001. Мир современных медиа. Москва.

10. W a r d M. 2002. Journalism online. N. Y.

Резюме

В данной статье рассматриваются вопросы об интернет-журналистике. Сегодня интернет становится одним из самых перспективных СМИ. Из года в год увеличивается количество потребителей интернета и активно внедряются на практику новые формы электронной прессы. Интернет-журналистика вместе с прессой, радио и тележурналистикой определяют информационную политику общества. Развитие Интернет-журналистики осуществляется во взаимосвязи и взаимозависимости с другими видами СМИ.